



## ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ” СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 5/28

Бор-Өндөр сум

П.Дорнодыг бага ангийн багшаар  
түр томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1.4, 101 дүгээр зүйлийн 101.1, 145 дугаар зүйлийн 145.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бага ангийн багш Д.Баяржаргал нь жирэмсэн болон амаржсаны амралт авсан тул түүнийг ажилдаа эргэн орох хүртлэх хугацаанд Пүрэвийн Дорнодыг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн бага ангийн багшийн албан тушаалд түр томилсугай.

2.П.Дорнодын албан тушаалын үндсэн цалинг ТҮБД-3 зэрэглэл 1,484,000 (нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянга) төгрөгөөр тогтоож, хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн нэмэгдэл хөлс олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Хууль тогтоомж, дүрэм журмыг чанд мөрдөн ажиллахыг бага ангийн багш (П.Дорнод)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙН  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.АМАРЖАРГАЛ

